

БАТЛАВ: ХАБҮЛЛ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.АМАР



СОРИЛТЫН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ХӨТӨЛБӨР

/ 2020 оны II ээлж /

Хамрах хүрээ: Үндэсний түвшинд итгэмжлэгдсэн төрийн, хувийн өмчит, орон нутгийн хяналтын сүлжээ лабораториудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй лабораториуд хамарна.

Хөтөлбөрийн зорилго: Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын хими, микробиологийн хяналтын чиглэлээр шинжилгээний үр дүнгийн үнэн зөвийг хянах, шинжилгээний дүнгийн нэгдмэл байдал, хэмжлийн нарийвчлалыг шалгах, гадаад хяналтыг зохион байгуулснаар оролцогч лабораториудын шинжилгээний ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

Хөтөлбөр зохион байгуулах чиглэл: Ур чадварын үнэлгээг:

Хими - Багажит шинжилгээний аргаар хиаманд **нитрит мг/кг**, уламжлалт аргаар ундны усанд **сульфат мг/л**, цайнд **танин, %** тодорхойлох;

Нян судлал- Шингэн хүнс, печень, хуурай шоколад болон шингэн тэжээлт орчин **халдварлуулсан нян**, улаан лоолийн жүүсэнд **хөгц мөөгөнцөр**, бактерид **үйлчлэх идэвхи** тодорхойлох,

Хөтөлбөр хэрэгжих хугацаа: 2020 оны 09 сарын 30-ны өдрөөс 11 сарын 15 хүртэл

Хөтөлбөрийн чиглэл

№	Хөтөлбөрийн чиглэл		Дээж	Үзүүлэлт	Шинжилгээний аргын стандарт	
1	Ур чадварын сорилтын лаборатори	Хүнсний химийн шинжилгээ	Багажит шинжилгээ	Хиаманд	Нитрит мг/кг	MNS 6825:2020
			Уламжлалт шинжилгээ	Ундны усанд	Сульфат мг/л	MNS 6271:2011
				Цайнд	Танин %тодорхойлох;	MNS 4137: 1992
2		Микробиологийн шинжилгээ	Шингэн хүнс, печень, болон шингэн тэжээлт орчин	бактерийн стандарт өсгөвөр тодорхойлох;	MNS ISO 7218:1996 Микробиологи-Микробиологийн шинжилгээний ерөнхий заавар.	
			Улаан лоолийн жүүс	Хөгц мөөгөнцрийн стандарт өсгөвөр тодоройлох;	MNS 5132:2002 Хүнсний бүтээгдэхүүн Хөгц мөөгөнцар тодорхойлох шинжилгээний арга	
			Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд / санитол /	Нянд үйлчлэх идэвхи тодорхойлох	Нян судлал. Халдваргүйтгэлийн бодисын нянд үйлчлэх идэвхийг тодорхойлох нян судлалын шинжилгээний арга. MNS 6236:2011	